



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг

Утас/Факс: 976-7054 3179

И-мэйл: goviumber@audit.gov.mn

2024.07.30 № 243

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох аймгийн Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8: 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

## Дүгнэлт

Ардчилсан намын аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Ардчилсан намын мөрийн хөтөлбөр (25 хуудас)-г хавсаргав.

Хувийг: Аймагийн сонгуулийн хороонд

Хавсралт 7... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

Б.АНХТУЯА

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024  
ОНЫЭЭЛЖИТ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД АРДЧИЛСАН НАМААС  
ДЭВШҮҮЛЖ БУЙ МӨРИЙН ХӨТӨЛБӨР



**ГОВЬСҮМБЭР ХӨГЖИНӨ**

**“3+30+300”**

**ЭРЧИМТ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

## УДИРТГАЛ

Монгол Улсын тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт ардчиллаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх чөлөө, хуулийн засаглал, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөөх баруун төвийн намын хувьд

Ардчилсан нам 2024 оны орон нутгийн ээлжит сонгуульд стратегийн 9 заалт, 9 бүлэг бүхий “Чойр хот” Эрчимт хөгжлийн төлөвлөгөөг танилцуулж байна.

Говьсүмбэр аймгийн Ардчилсан нам 2024 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрөө “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”, “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”, “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай - Эрх зүйн баримт бичиг, Ардчилсан намын үзэл баримтлал, мөрийн хөтөлбөр болон бусад холбогдох хууль, дүрэмд нийцүүлэн боловсруулав.

2024 – 2028 он хүртэл Говьсүмбэр аймгийг Улсын жишигт хүрсэн хот болгох түүхэн ач холбогдол бүхий “Чойр хот эрчимт хөгжил” мөрийн хөтөлбөрийг дараах томоохон төслүүдэд суурилан 4 зорилт, 58-н арга хэмжээний хүрээнд боловсруулав.

0000000 1

*Аннамж*

## НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ

- 1.1. Өрсөлдөх чадвартай боловсрол
- 1.2. Эрүүл мэндийн төгс үйлчилгээ
- 1.3. Хүн амын хөгжил
- 1.4. Хүн амын өсөлт
- 1.5. Өрх гэр бүл хүүхэд
- 1.6. Ахмад настан, Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
- 1.7. Нийгмийн хамгаалал
- 1.8. Соёл, урлаг,
- 1.9 Нийтийн биеийн тамир, спорт
- 1.10 Эдийн засгийн эрх чөлөөтэй иргэн



## ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

- 2.1. Жижиг дунд бизнес
- 2.2. Хөдөлмөрийн зах зээл
- 2.3. Аж үйлдвэрлэлийн салбар
- 2.4. Эрдэс баялгийн салбар
- 2.5. Дэд бүтэц
- 2.6 Эрчим хүч
- 2.7. Хүнсний үйлдвэрлэл
- 2.8 Байгалийн баялагийн тэгш хувиарлалт
- 2.9 Орон сууцжуулах хөтөлбөр
- 2.10 Бизнес эрхлэх тэгш боломж

0000000 2

*Amnyan*

## ГУРАВ. ЭКО ГОВЬСҮМБЭР

- 3.1. Хүнсний аюулгүй байдал
- 3.2. Аялал жуулчлал
- 3.3. Орон нутгийн хөгжил
- 3.4. "Чинээлэг малчин" хөтөлбөр
- 3.5. Мал аж ахуй
- 3.6. Газар тариалан
- 3.7. Чойр хотын хөгжил
- 3.8. Хүрээлэн буй орчин, ногоон хөгжил
- 3.9. Байгаль орчны тогтвортой хөгжил
- 3.10 Усны бодлого

### НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ

#### 1.1. ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ БОЛОВСРОЛ

1.1.1. Боловсролын салбар Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн сургалтын анги танхим тоног төхөөрөмжийн бааз суурийг түшиглэн Их дээд сургуулиудын магистер докторын сургалтыг орон нутагт зохион байгуулах.

1.1.2. Ар гэр нь санхүүгийн боломж муутай сурлага сайтай сурагчидтай гэрээ байгуулан Их дээд сургуульд суралцах боломжийг бүрдүүлж сурсан мэдснээ орон нутгийн хөгжилд зориулах чадварлаг боловсон хүчин бэлтгэх

1.1.3. Мэргэжлийн боловсролын сургуулиудад хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээнд нийцсэн нарийн мэргэжлийн шинэ ангиудыг нээж, сургалтын хөтөлбөрийг шинэчилнэ.

1.1.4. Багш нарын мэдлэг, ур чадварыг тухай бүрд нь дээшлүүлж, давтан сургах "Чадварлаг багш" хөтөлбөрийг боловсруулах хэрэгжүүлж, Багш нарын нийгмийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх

#### 1.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨГС ҮЙЛЧИЛГЭЭ

1.2.1 Эмнэлгүүдийг гүйцэтгэлд нь үндэслэн бие даалгаж, чанар, үр дүнг дээшлүүлнэ. Иргэд болон мэргэжлийн шинжээчдийг мэдээллээр ханган шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцуулна. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын

0000000 3

*Amujan*

гүйцэтгэлийг сайжруулж, даатгуулагчдын өмнө үүрэх хариуцлага, үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох замаар даатгуулагчдын сэтгэл ханамжийг сайжруулна.

1.2.2. Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөл, эх болон нярайн эндэгдлийг бууруулж, иргэд эрүүл мэндийн шалтгаанаар санхүүгийн эрсдэлд орохгүй байхаар эрүүл мэндийн даатгалын цахим тогтолцоог түргэн шуурхай болгох.

1.2.3. Салбарын хүний нөөцийн сургалт, чанар хүртээмж, төлөвлөлтийг шинэ шатанд гаргаж, нийгмийн асуудлыг цогцоор шийдвэрлэнэ.

1.2.4. Аймгийн нэгдсэн эмнэлгийн Хорт хавдрын оношилгоо, эмчилгээний иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангах. .

1.2.5 Орон нутгийн иргэд хүссэн үедээ эмийн үнийн хөнгөлөлтийг авах боломжийг бүрдүүлж эмийн үнийн хөнгөлөлтийн зардлын төсвийг нэмэгдүүлэх.

### 1.3. ХҮН АМЫН ХӨГЖИЛ

1.3.1. Хүүхдийн ордны барилгыг барих, аймагтаа хүүхдийн эрхийг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх замаар хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулна.

1.3.2. Орон сууцны хороолол, хаус барих аж ахуй нэгж байгууллагын дэмжиж газар дэд бүтцийг шийдвэрлэж өгөх.

1.3.3 Залуучуудыг боловсрол эзэмшихэд туслах хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор тэтгэлэг олгож буй аж ахуйн нэгж, хувь хүнийг урамшуулах, дотоодын болоод орон нутагт тэтгэлгийн тоог нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлнэ

### 1.4 ХҮН АМЫН ӨСӨЛТ

1.4.1 Залуу гэр бүл, зорилтот өрхийг орон сууцанд ороход дэмжлэг үзүүлэх.

1.4.2 Ипотекийн зээлийг үргэлжлүүлнэ. Гэр хорооллын дахин төлөвлөлтийг ипотекийн зээлтэй уялдуулна.

### 1.5 ГЭР БҮЛ, ХҮҮХЭД

1.5.1 Орон нутагт ажиллаж буй залуучуудыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.5.2 Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх орон нутгийн хүрээний төсөл хөтөлбөрийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, илүү үр дүнтэй хэлбэрээр шинэчлэн зохион байгуулна.

0000000 3

*Амтунуу*

0000000 5

1.5.3 Хуримын өргөөтэй болох Залуу гэр бүлийг хурмын өргөөндөө албан ёсоор баталгаажуулах.

1.5.4 Хүүхэд бүрийг хөгжүүлж, бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, Монгол орныхоо байгаль, түүх, үндэсний хэл соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгох “Зөв Монгол хүүхэд” хөтөлбөрийг сэргээн орон нутагтаа хэрэгжүүлэх.

1.5.5 Цэцэрлэг, сургуулийн нэг ангийн хүүхдийн тоог 30-аас хэтрүүлэхгүй байх стандартыг хэрэгжүүлнэ.

1.1.6. Малчин өрхийн сургуулийн өмнөх насны хүүхдийг гэр цэцэрлэгт хамруулах сургалтын тогтолцоог бүрдүүлнэ.

## 1.6. АХМАД НАСТАН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН

1.6.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бусдын адил бизнес эрхлэх, сурч, хөдөлмөрлөх, бие даан амьдрахад нь туслах, сэргээн засах, нийгмийн харилцаанд ороход туслан дэмжих зэргээр тэдний хэрэгцээнд нийцсэн олон талт мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ.

1.6.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний асран хамгаалагчдыг чухалчлан авч үзэж бодлогоор дэмжиж бодитоор хэрэгжүүлнэ.

1.6.3. Эмнэлэг эрүүл мэндийн газруудад хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан дэд бүтэц, орчин бий болгоно.

1.6.4. Үйлчилгээний газар, шинээр баригдаж байгаа барилга байгууламж, явган хүний зам, гэрлэн дохиог хөгжлийн бэрхшээлтэй хүн чөлөөтэй зорчих олон улсын стандартын шаардлагад нийцүүлж өөрчилнө.

1.6.5 Ахмадын амралт сувилалын төвтэй болох асуудлыг бодлогоор дэмжинэ.

## 1.7. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

1.7.1 Төрийн албанаас бизнесийн салбарт шилжиж баялаг бүтээх иргэдийнхээ бизнесийн эхлэлтийн хөрөнгө оруулалтыг жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас санхүүжүүлдэг журам боловсруулж шилжинэ.

0000000 3

0000000 6



1.7.2 Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, зарим төрийн чиг үүргийг хамтран хэрэгжүүлэх бодлогыг баримтлан ажиллана.

## 1.8. СОЁЛ, УРЛАГ

1.8.1. Аймагт Спорт цогцолбор, бассейн, сургалтын төв бүхийн спорт комплекс бий болгох

1.8.2. Баянтал, Шивээговь суманд 250 хүний суудалтай соёлын төвийг шинээр барьж ашиглалтад оруулах

## 1.9 НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТ

1.9.1. Баянтал суманд стандартын спорт заалтай болгох

1.9.2. Спортын олон улсын ~~хэмжээний~~ томоохон арга хэмжээ, фестиваль, уралдаан, тэмцээнийг зохион байгуулахад орон нутгаас дэмжлэг үзүүлнэ

1.9.3. Олимпын олон төрлөөр өсвөр, залуучууд, насанд хүрэгчдийн үндэсний хэмжээний тэмцээнүүдийг зохион байгуулахад орон нутгаас дэмжлэг үзүүлнэ

## 1.10 ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ ИРГЭН

УСА0055 9019049

1.10.1 Баялаг бүтээгчдээ дэмжиж, монгол хүний орлогыг нэмэгдүүлнэ.

1.10.2 “Өрх бүр баялаг бүтээгч” үндэсний хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлнэ

1.10.3 Хашаандаа сайхан амьдарья төслийн хүрээнд - Хөдөөгийн болон гэр хорооллын иргэдийг хувийн орон сууцтай болгох чиглэлээр хувийн хэвшлийн оролцоог хангаж ажиллана.

## ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

### 2.1 ЖИЖИГ ДУНД БИЗНЕС

2.1.1 Орон нутгийн жижиг дундын үйлдвэрлэлийг дэмжих тусгай сан бий болгох.

2.1.2 Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэх бизнес, төсөл, арга хэмжээний жагсаалтыг шинэчилж, эдийн засгийн тэргүүлэх чиглэл, нийгмийн зорилтот бүлгийг харгалзан үздэг зарчмыг баримтална.

0000000 7

*Амтун*

## 2.2 ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

2.2.1. Малын гаралтай түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэн ажлын байрыг бий болгоно.

2.2.2. Бүсийн сургалтуудыг аймагтаа зохион байгуулж бизнес эрхлэгчдийг дэмжин аймгийн эдийн засгийн эргэлтийг сайжруулна.

## 2.3 АЖ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР

2.3.1 Нүүрс-химийн боловсруулах үйлдвэрүүдийг бүс нутгийн нөхцөл, зах зээлийн байдалтай уялдуулж, байгалийн нөөцөд тулгуурлан үе шаттайгаар барьж байгуулна.

2.3.2 Хөдөө аж ахуйн боловсруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, санхүүжилтийн найдвартай тогтолцоо бий болгох, олон улсын стандарт нутагшуулах, экспортлох цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

## 2.4 ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАР

2.4.1 Говьсүмбэр аймгийн нутагт эдийн засгийн чөлөөт бүс байгуулж жилд 16 сая тонн нүүрснээс кокс, улмаар 15,0 сая тонн ширэм, ган үйлдвэрлэн экспортлох хар төмөрлөгийн цогцолборыг ашиглалтад оруулахад бодлогын дэмжлэг үзүүлнэ.

## 2.5 ДЭД БҮТЭЦ

2.5.1 Олон улсын автозам төмөр замуудыг түшиглэн тээвэр логистикийн төвүүдийг үе шаттай байгуулна

2.5.2 Шивээговь сумын төвд 3,5 км Баягтал суманд 2,4 км хатуу хучилттай зам барина.

2.5.3 Сумдын ашиглалтын хугацаа дуусч байгаа ус дулааны шугамуудыг шинэчлэнэ.

## 2.6 ЭРЧИМ ХҮЧ

2.6.1 Шивээ овоогийн уурхайг түшиглэн цахилгаан станц байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ.

0000000 8

*Амтун*

2.6.2 Дулааны станц, дулааны сүлжээ байгуулах ажлыг дэмжиж хамтран хэрэгжүүлж, ашиглалтад оруулна.

## 2.7 ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ


2.7.1 Малыг стандарт шаардлагын дагуу үйлдвэрийн аргаар бойлж лабороторийн шинжилгээнд хамруулж худалдаанд гаргах

2.7.2 Гахайны мах, өндөгний хэрэглээгээ аймгаасаа хангах зорилгоор бодлогын дэмжлэг үзүүлнэ.

## 2.8 БАЙГАЛИЙН БАЯЛАГИЙН ТЭГШ ХУВИАРЛАЛТ

2.8.1 Байгалийн баялгаас улсын төсөвт орж байгаа орлогын 30 хүртэлх хувийг орон нутагт нь шууд хуваарилдаг тогтолцоог бүрдүүлнэ

2.8.2 Хууль бус лицензүүдийг цуцлуулж орон нутгийн өмчит уурхайг байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ.



## 2.9 ОРОН СУУЦЖУУЛАХ ХӨТӨЛБӨР

2.9.1 Баянтал суман төр хувийн хэвшлийн түншлэлээр 120 айлын орон сууц барина.

2.9.2 СӨХ байгуулж үйл ажиллагааг нь жигдрүүлнэ.

## 2.10 БИЗНЕС ЭРХЛЭХ ТЭГШ БОЛОМЖ

2.10.1 Гарааны бизнесийг бодлогоор дэмжинэ.

2.10.2 Орон нутгийн ЖДҮ дэмжих сангийн тайлан, зарцуулалтыг иргэдийн хяналттай болгоно.

## ГУРАВ. ЭКО ГОВЬСҮМБЭР

### 3.1 ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

3.1.1 Өвлийн хүлэмж байгуулах Аж ахуй нэгж иргэний дэмжинэ.

0000000 9

3.1.2 Хүнсний хяналтын тогтолцоог орчин үеийн ухаалаг технологид тулгуурлан төгөлдөржүүлж, хүнсний бүтээгдэхүүний бүх лабораторийг мэргэжлийн холбоод болон хувийн хэвшилд шилжүүлнэ.

### 3.2 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

3.2.1. Гадаад болон дотоод аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор хувийн хэвшилд суурилсан кемп баазуудыг бодлогоор дэмжих

3.2.2 Чойрын богд уулыг аялал жуулчлалын бүс болгох, байгаль экологийн тэнцвэрийг хадгалах зорилгоор хатуу хучилттай зам тавих ажлыг эхлүүлэх

### 3.3. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

3.3.1 Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх цогц бодлогыг боловсруулж, нийгмийн хариуцлагын гэрээг боловсруулан байгуулах.

3.3.2 Сумдад үүрэн утасны сүлжээ өргөтгөж, сүүлийн үеийн үзүүлэлт сайтай камер байрлуулж малын хулгайтай тэмцэх, малчдыг шуурхай мэдээ мэдээллээр хангаж ажиллах бололцоог бүрдүүлнэ.

### 3.4 ЧИНЭЭЛЭГ МАЛЧИН ХӨТӨЛБӨР

3.4.1 Чинээлэг малчин хөтөлбөрийг бүх сумдад хэрэгжүүлнэ.

3.4.2 Хадлангийн талбайг хамгаалах эрхзүйн орчин бүрдүүлнэ.

### 3.5. МАЛ АЖ АХУЙ

3.5.1 Хөдөөгийн малчин өрхийг дэмжин хоршоонд тулгуурлан “Малжуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.

3.5.2 Бэлчээр усжуулах гүн өрмийн худгийг нэмэгдүүлэх

### 3.6. ГАЗАР ТАРИАЛАН

3.6.1 Газар тариалангийн үйлдвэрлэлийн мэргэжлийн ажиллах хүчний хангамж, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.

3.6.2 Хаялага нуурын орчмын тариалан эрхээгчдийг бодлогоор дэмжинэ.

000000010



### 3.7. ЧОЙР ХОТЫН ХӨГЖИЛ

3.7.1 Иргэд өөрийн өмчилж авсан хашааны газар дээр айл, хөрш, гудамжаараа нэгдэн төлөвлөлт хийж, инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдсон амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.

3.7.2 Гэр хорооллыг инженерийн дэд бүтэц /цэвэр ус, бохир ус ариутгах татуурга, интернэт шилэн кабель/-д холбож, халаалтыг төвлөрсөн болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоотой хэрэгжүүлж, амьдран суух байшингаа барихад нь урт хугацаатай, хүү багатай, орон сууцны ипотекийн зээлээр санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллана

### 3.8 ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН НОГООН ХӨГЖИЛ

3.8.1 Орчноо ногооруулсан иргэд, аж ахуйн нэгжийг урамшуулах тогтолцоог бий болгоно. .

3.8.2 Гэр хорооллын дахин төлөвлөлтөөс чөлөөлөгдсөн газар дээр иргэдийн амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх, эрүүл амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор цэцэрлэгт хүрээлэн ГАРДЕН – 2 байгууламжийг байрьж байгуулна

3.8.3. Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгохын тулд хогийг худалдан авч дахин боловсруулах чиглэлээр хог боловсруулах, буцаан ашиглах үйлдвэр байгуулж, иргэд хогоо ангилан ялгаж тушаах хувийн хэвшлийг дэмжин ажиллах.

3.8.4 Аймаг сумын төвүүдэд 3000 мод тарьж ургуулна.

3.8.5 Ногоон байгууламжийн хашаануудыг шинэчлэнэ.

### 3.9 БАЙГАЛЬ ОРЧИН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

3.9.1 Малчны хоршоо бүлгүүдтэй хамтран ажиллаж бэлчээрийн доройтлыг багасгана.

3.9.2 Шинээр цэвэрлэх байгууламжууд барьж оршин суугчдын байгальд учруулах сөрөг нөлөөг багасна.

### 3.10 УСНЫ БОДЛОГО

3.10.1 Говь нутгийг усжуулах “ХЭРЛЭН-ГОВЬ” төслийг бодлогоор дэмжинэ.

000000011



3.10.2 Булаг шандны эхийг хамгаалах ажлыг орон нутгийн иргэдийн оролцоотойноор хийж гүйцэтгэнэ.



000000012



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ ОРОН НУТГИЙН  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ АРДЧИЛСАН НАМЫН  
ЭРЧИМТ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

“ЧОЙР ХОТ”

2024 он

Монгол Улсын тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт ардчиллаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх чөлөө, хуулийн засаглал, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөөх баруун төвийн намын хувьд

Ардчилсан нам 2024 оны орон нутгийн ээлжит сонгуульд стратегийн 9 заалт, 9 бүлэг бүхий “Чойр хот” Эрчимт хөгжлийн төлөвлөгөөг танилцуулж байна.

Говьсүмбэр аймгийн Ардчилсан нам 2024 оны Сүмбэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрөө “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”, “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”, “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай - Эрх зүйн баримт бичиг, Ардчилсан намын үзэл баримтлал, мөрийн хөтөлбөр болон бусад холбогдох хууль, дүрэмд нийцүүлэн боловсруулав.

2024 – 2028 он хүртэл Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумыг Улсын жишигт хүрсэн сум болгох түүхэн ач холбогдол бүхий “Чойр хот эрчимт хөгжил” мөрийн хөтөлбөрийг дараах томоохон төслүүдэд суурилан 4 зорилт, 77 арга хэмжээний хүрээнд боловсруулав.

000000013

*Amnyal*



## НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ

- 1.1. Өрсөлдөх чадвартай боловсрол
- 1.2. Эрүүл мэндийн төгс үйлчилгээ
- 1.3. Хүн амын хөгжил
- 1.4. Хүн амын өсөлт
- 1.5. Өрх гэр бүл хүүхэд
- 1.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
- 1.7. Нийгмийн хамгаалал
- 1.8. Соёл, урлаг, спорт

## ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

- 2.1. Жижиг дунд бизнес
- 2.2. Хөдөлмөрийн зах зээл
- 2.3. Аж үйлдвэрлэлийн салбар
- 2.4. Эрдэс баялгийн салбар
- 2.5. Дэд бүтэц
- 2.6. Эрчим хүч
- 2.7. Аялал жуулчлал
- 2.8. Хүнсний үйлдвэрлэл



## ГУРАВ. ЭЗЭН ГОВЬСҮМБЭР

- 3.1. Хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжил
- 3.2. Орон нутгийн хөгжил
- 3.3. Чинээлэг малчин” хөтөлбөр
- 3.4. Мал аж ахуй
- 3.5. Газар тариалан
- 3.6. Чойр хотын хөгжил

## ДӨРӨВ. АЮУЛГҮЙ АМГАЛАН ГОВЬСҮМБЭР

- 4.1. Батлан хамгаалах бодлого
- 4.2. Хүрээлэн буй орчин, ногоон хөгжил
- 4.3. Экосистемийн тэнцвэртэй байдал
- 4.4. Байгаль орчны тогтвортой хөгжил

## НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ

### 1.1. ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ БОЛОВСРОЛ

000000014

*Amnyan*

1.1.1. Боловсролын салбар Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн сургалтын анги танхим тоног төхөөрөмжийн бааз суурийг түшиглэн Их дээд сургуулиудын магистер докторын сургалтыг орон нутагт зохион байгуулах.

1.1.2. Сумын харъяат идэвх санаачлагатай, сурлага, урлагаар бусдыгаа манлайлагч, төлбөрийн боломжгүй оюутан залуусыг судалгаанд үндэслэн Их дээд сургуульд суралцах боломжийг бүрдүүлж, тэтгэлэгт хамруулж гэрээгээр сургаж, сурсан мэдсэнээ орон нутгийн хөгжилд зориулах чадварлаг боловсон хүчин бэлтгэх ажлыг зохион байгуулна.

1.1.3. Хүүхэд бүрийг хөгжүүлж, бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, Монгол орныхоо байгаль, түүх, үндэсний хэл соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгох "Зөв Монгол хүүхэд" хөтөлбөрийг сэргээн орон нутагтаа хэрэгжүүлэх.

1.1.4. Цэцэрлэг, сургуулийн нэг ангийн хүүхдийн тоог 30-аас хэтрүүлэхгүй байх стандартыг хэрэгжүүлнэ.

1.1.5. Малчин өрхийн сургуулийн өмнөх насны хүүхдийг гэр цэцэрлэгт хамруулах сургалтын тогтолцоог бүрдүүлнэ.

1.1.6. Мэргэжлийн боловсролын сургуулиудад хөдөмөрийн зах зээлийн хэрэгцээнд нийцсэн нарийн мэргэжлийн шинэ ангиудыг нээж, сургалтын хөтөлбөрийг шинэчилнэ.

1.1.7. Багш нарын мэдлэг, ур чадварыг тухай бүрд нь дээшлүүлж, давтан сургах "Чадварлаг багш" хөтөлбөрийг боловсруулах хэрэгжүүлж, Багш нарын нийгмийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх

1.1.8. Тусгай хэрэгцээт (хөгжлийн бэрхшээлтэй) иргэдтэй ажиллах мэргэжилтэн, дохионы хэлний орчуулагч, тусгай сургуулийн багш, мэргэжилтнүүдийг бэлтгэх төлөвлөгөөт арга хэмжээнүүдийг авч, нийгмийн баталгааг нь эрс дээшлүүлнэ.

1.1.9 Сумын хэмжээнд сурагчдын сурлагын чанарт анхаарч олон улс, улс, бүсийн хэмжээний уралдаан тэмцээн, олимпиадад шавь нар нь амжилт гаргасан багш нарыг урамшуулалын систем нэвтрүүлнэ.

## 1.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨГС ҮЙЛЧИЛГЭЭ

Эмнэлгүүдийг гүйцэтгэлд нь үндэслэн бие даалгаж, чанар, үр дүнг дээшлүүлнэ. Иргэд болон мэргэжлийн шинжээчдийг мэдээллээр ханган шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцуулна. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын гүйцэтгэлийг сайжруулж, даатгуулагчдын өмнө үүрэх хариуцлага, үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох замаар даатгуулагчдын сэтгэл ханамжийг сайжруулна.

1.2.1. Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөл, эх болон нярайн эндэгдлийг бууруулж, иргэд эрүүл мэндийн шалтгаанаар санхүүгийн эрсдэлд орохгүй байхаар эрүүл мэндийн даатгалын цахим тогтолцоог түргэн шуурхай болгох.

1.2.2. Салбарын хүний нөөцийн сургалт, чанар хүртээмж, төлөвлөлтийг шинэ шатанд гаргаж, нийгмийн асуудлыг цогцоор шийдвэрлэнэ.

1.2.3. Аймгийн нэгдсэн эмнэлгийн Хорт хавдрын оношилгоо, эмчилгээний иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангах.

1.2.4. Амиа хорлолтын шалтгаан сэтгэл гутралын өвчлөл, хар тамхи, мансуурах бодист донтох, хамаарлын болон бусад сэтгэцийн эмгэг өвчнийг эрт илрүүлж, эмчлэх, нөхөн сэргээх эмчилгээ үйлчилгээг сайжруулах.

000000015



1.2.5. Эрүүл мэндийн салбарын боловсон хүчний хангалт, нөөцийг бүрдүүлэх үүднээс оюутан сурагчдыг "Оюутны зээлд хамруулж орон нутагт ажиллах боломжийг олгох

1.2.6. Эрүүл мэндийн даатгал голлосон урьдчилан сэргийлэх болон эмнэлгийн тусламж үйлчилгээний хүрээг өргөтгөх бөгөөд эрүүл мэндийн даатгалын цахим картыг нэвтрүүлнэ.

1.2.7. Орон нутгийн иргэд хүссэн үедээ эмийн үнийн хөнгөлөлтийг авах боломжийг бүрдүүлж эмийн үнийн хөнгөлөлтийн зардлын төсвийг нэмэгдүүлэх.

### 1.3. ХҮН АМЫН ХӨГЖИЛ, ХҮН АМЫН ӨСӨЛТ ӨРХ ГЭР БҮЛ

1.3.1. Хүүхдийн ордны барилгыг барих, аймагтаа хүүхдийн эрхийг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх замаар хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулна.

1.3.2. Хуримын өргөөтэй болох Залуу гэр бүлийг хурмын өргөөндөө албан ёсоор баталгаажуулах.

1.3.3. Ипотекийн зээлийг үргэлжлүүлнэ. Гэр хорооллын дахин төлөвлөлтийг ипотекийн зээлтэй уялдуулна.

1.3.4. Орон сууцны хороолол, хаус барих аж ахуй нэгж байгууллагын дэмжиж газар дэд бүтцийг шийдвэрлэж өгөх.


1.3.5. Залуу гэр бүл, зорилтот өрхийг орон сууцанд ороход дэмжлэг үзүүлэх.

#### ЗАЛУУЧУУД

1.3.6. Залуучуудыг боловсрол эзэмшихэд туслах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор тэтгэлэг олгож буй аж ахуйн нэгж, хувь хүнийг урамшуулах, дотоодын болоод орон нутагт тэтгэлгийн тоог нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлнэ.

1.3.7. Орон нутагт ажиллаж буй залуучуудыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.3.8. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх орон нутгийн хүрээний төсөл хөтөлбөрийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, илүү үр дүнтэй хэлбэрээр шинэчлэн зохион байгуулна



#### ЗАЛУУ ГЭР БҮЛ

1.3.9. Ажил, хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ өргөжүүлэх, амьдрах орчноо хамтдаа сайжруулах мэдлэг, ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.

1.3.10. Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн асуудалд онцгой анхаарч, цэцэрлэгийн өмнөх насны хүүхдийг хүмүүжүүлэх бодлогыг шинэчлэн, хүүхдийг гэр бүлийнхээ орчинд эцэг, эхтэйгээ хамт хүмүүжин төлөвших хөтөлбөр, заах аргыг хөгжүүлнэ.

### 1.4. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН

1.4.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бусдын адил бизнес эрхлэх, сурч, хөдөлмөрлөх, бие даан амьдрахад нь туслах, сэргээн засах, нийгмийн харилцаанд ороход туслан дэмжих зэргээр тэдний хэрэгцээнд нийцсэн олон талт мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ.

1.4.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний асран хамгаалагчдыг чухалчлан авч үзэж бодлогоор дэмжиж бодитоор хэрэгжүүлнэ.

1.4.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд зориулсан сэргээн засах, хөгжлийн цогцолбор төвийг орон нутагт байгуулна.

1.4.4. Эмнэлэг эрүүл мэндийн газруудад хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан дэд бүтэц, орчин бий болгоно.

000000018

  
Page 6

1.4.5. Үйлчилгээний газар, шинээр баригдаж байгаа барилга байгууламж, явган хүний зам, гэрлэн дохиог хөгжлийн бэрхшээлтэй хүн чөлөөтэй зорчих олон улсын стандартын шаардлагад нийцүүлж өөрчилнө.

## 1.5. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

1.5.1. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний дэргэд Ахмадын амралт сувилалтын төвтэй болох.

1.5.2. Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогоор тодорхойлсон олон давхрагат тэтгэврийн тогтолцоог бүрдүүлж, тэтгэвэр авагчдын орлогыг эрс нэмэгдүүлнэ.

## 1.6. СОЁЛ, УРЛАГ, СПОРТ

1.6.1. Аймагт Спорт цогцолбор, бассейн, сургалтын төв бүхийн спорт комплекс бий болгох

1.6.2. Суманд стандартын спорт ордонтой болгох

1.6.3. Спортын олон улсын хэмжээний томоохон арга хэмжээ, фестиваль, уралдаан, тэмцээнийг зохион байгуулахад орон нутгаас дэмжлэг үзүүлнэ

1.6.4. Олимпын олон төрлөөр өсвөр, залуучууд, насанд хүрэгчдийн үндэсний хэмжээний тэмцээнүүдийг зохион байгуулахад орон нутгаас дэмжлэг үзүүлнэ

## ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

### ЖИЖИГ ДУНД БИЗНЕС

2.1.1. Баялаг бүтээгчдээ дэмжиж, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.

“Өрх бүр баялаг бүтээгч” үндэсний хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлнэ.

2.1.2. Орон нутгийн жижиг дундын үйлдвэрлэлийг дэмжих тусгай сан бий болгох.

2.1.3. Жижиг үйлдвэрлэлийг технологийн шийдлээр дэмжихэд төрөөс анхаарч, хэрэгжүүлэх механизмыг бий болгоно.

2.1.4. Жижиг дунд бизнесийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, гарааны бизнесийн гарцыг нэмэгдүүлэхэд шаардлагатай мэдээллийн “Биг дата” үүсгэж, нэгдсэн платформ бий болгон аюулгүй байдлыг хангана.

2.1.5. Төрийн албанаас бизнесийн салбарт шилжиж баялаг бүтээх иргэдийнхээ бизнесийн эхлэлтийн хөрөнгө оруулалтыг жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас санхүүжүүлдэг журам боловсруулж шилжинэ.

### ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

2.1.6. Малын гаралтай түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэн ажлын байрыг бий болгоно.

2.1.7. Бүсийн сургалтуудыг аймагтаа зохион байгуулж бизнес эрхлэгчдийг дэмжин аймгийн эдийн засгийн эргэлтийг сайжруулна.

2.1.8. Төрийн албанаас эрт тэтгэвэртээ гарсан хөдөлмөрлөх чадвартай иргэдийг жижиг дунд, бичил бизнесийн салбарт ажиллах, зөвлөгөө өгөх боломжийг хангаж ажиллана.

000000017

*Амгун*  
Page 7

## АЖ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР

2.1.9. Нүүрс-химийн боловсруулах үйлдвэрүүдийг бүс нутгийн нөхцөл, зах зээлийн байдалтай уялдуулж, байгалийн нөөцөд тулгуурлан үе шаттайгаар барьж байгуулна.

2.1.10. Хөдөө аж ахуйн боловсруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, санхүүжилтийн найдвартай тогтолцоо бий болгох, олон улсын стандарт нутагшуулах, экспортлох цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.1.11. Говьсүмбэр аймгийн нутагт эдийн засгийн чөлөөт бүс байгуулж жилд 16 сая тонн нүүрснээс кокс, улмаар 15.0 сая тонн ширэм, ган үйлдвэрлэн экспортлох хар төмөрлөгийн цогцолборыг ашиглалтад оруулахад бодлогын дэмжлэг үзүүлнэ.

## ДЭД БҮТЭЦ

2.1.12. Уул уурхай, ашигт малтмалын ордын бүтээгдэхүүн тээвэрлэх тусгай зориулалтын болон аялал жуулчлалын бүс нутгийг холбосон замыг төр хувийн хэвшлийн түншлэлээр гүйцэтгүүлэх чиглэлийг баримтална.

2.1.13. Олон улс чанартай авто замуудыг камержуулж зорчигч үйлчилгээний төв барина.

2.1.14. Олон улсын автозам төмөр замуудыг түшиглэн тээвэр логистикийн төвүүдийг үе шаттай байгуулна

### ЭРЧИМ ХҮЧ

Шивээ овоогийн уурхайг түшиглэн цахилгаан станц байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ.

2.1.15. Дулааны станц, дулааны сүлжээ байгуулах ажлыг дэмжиж хамтран хэрэгжүүлж, ашиглалтад оруулна.

2.1.16. Орон нутгийн эрчим хүчний газартай хамтран сумын эрчим хүчний чадлыг нэмэгдүүлж иргэдийн өмчлөлийн газарт бодлогоор цахилгаан хангамж нэмэгдүүлж ажиллана.

### АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

2.1.17. Гадаад болон дотоод аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор хувийн хэвшилд суурилсан кемп баазуудыг бодлогоор дэмжих


2.1.18. Суманд МӨНХ багийн нутагт Говьсүмбэр аймгаас улс, бүсийн наадамд айраг түрүүнд хурдалж байсан морины хийморийн шүтээнийг нутгийн иргэдийн оролцоотой шинээр бүтээн байгуулалт хийж аймгийн түүхэн цогцолбор газар болгоход зорьж ажиллана.

### ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

2.1.19. Малыг стандарт шаардлагын дагуу үйлдвэрийн аргаар бойлж, лабораторийн шинжилгээнд хамруулж, дотоод болон гадаадын зах зээлд / гадаад орнуудад экспортлох/ худалдаанд гаргах

2.1.20. Хүнсний хяналтын тогтолцоог орчин үеийн ухаалаг технологид тулгуурлан төгөлдөржүүлж, хүнсний бүтээгдэхүүний бүх лабораторийг мэргэжлийн холбоод болон хувийн хэвшилд шилжүүлнэ.

2.1.21. Аймгийн төвийн ЖДҮ-ийн барилгыг ашиглалтанд оруулж иргэд малчидыг безнис хийх таатай орчинг бүрлүүлж, сумын иргэлийг хямд эрүүл хүнс, бараа материалаар хангах бололцоог нэг доороос хүргэх нөхцөлөөр хангаж, нутгийн шинэ брэндийг бий болгоход зорилт тавих



000000018

*Amnyal*  
Page 8

## ГУРАВ.

### 3.1. ХОТ, ХӨДӨӨГИЙН ТЭНЦВЭРТЭЙ ХӨГЖИЛ

### 3.2. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

3.2.1. Байгалийн баялгаас улсын төсөвт орж байгаа орлогын 30 хүртэлх хувийг орон нутагт нь шууд хуваарилдаг тогтолцоог бүрдүүлнэ.

### 3.3. МАЛ АЖ АХУЙ

3.3.1. Малын бэлчээр сүйтгэх үлийн цагаан оготныг усгах ажлыг үе шаттай зохион байгуулна.

3.3.2. Чинээлэг малчин хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

Хөдөөгийн малчин өрхийг дэмжин хоршоонд тулгуурлан “Малжуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.

3.3.3. Бэлчээр усжуулах гүн өрмийн худгийг нэмэгдүүлэх

3.3.4. Малыг чанаржуулах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх

3.3.5. Малын гаралтай түүхий эдийг анхан шатны тордолт хийх цех байгуулах.

3.3.6. Малын гаралтай түүхий эдийг боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрүүдийг олноор байгуулж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ гадаадад гаргах

3.3.7. Малын гаралтай дайвар бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх цех байгуулах

3.3.8. Малчдыг нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамруулах

3.3.9. Малчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх.

3.3.10. Хөдөөгийн малчидад мах хадгалах зориулалттай хөргүүртэй болгох

3.3.11. Хөдөөгийн малчидад хадлангийн талбайг хашиж хямд үнэтэй өвс нийлүүлэх

### 3.4. ГАЗАР ТАРИАЛАН

3.4.1. Өвлийн хүлэмж байгуулах Аж ахуй нэгж иргэний дэмжинэ

3.4.2. Газар тариалангийн үйлдвэрлэлийн мэргэжлийн ажиллах хүчний хангамж, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.



### 3.5. ЧОЙР ХОТЫН ХӨГЖИЛ

3.5.1. Хашаандаа сайхан амьдарья төслийн хүрээнд - Хөдөөгийн болон гэр хорооллын иргэдийг хувийн орон сууцтай болгох чиглэлээр хувийн хэвшлийн оролцоог хангаж ажиллана.

3.5.2. Иргэд өөрийн өмчилж авсан хашааны газар дээр айл, хөрш, гудамжаараа нэгдэн төлөвлөлт хийж, инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдсон амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.

3.5.3. Дугуйн болон явган алхалтын замын сүлжээг нэмэгдүүлж, мэдээллийн нэгдсэн цахим сан үүсгэнэ.

3.5.4. Орчноо ногооруулсан иргэд, аж ахуйн нэгжийг урамшуулах тогтолцоог бий болгоно.

3.5.5. Гэр хорооллыг инженерийн дэд бүтэц /цэвэр ус, бохир ус ариутгах татуурга, интернэт шилэн кабель/-д холбож, халаалтыг төвлөрсөн болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоотой хэрэгжүүлж, амьдран суух байшингаа барихад нь урт хугацаатай, хүү багатай, орон сууцны ипотекийн зээлээр санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллана.

3.5.6. Иргэд өөрийн өмчилж авсан хашааны газар дээр айл, хөрш, гудамжаараа нэгдэн төлөвлөлт хийж, инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдсон, амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоотой хэрэгжүүлж, амьдран суух байшингаа барихад нь урт хугацаатай, хүү багатай, орон сууцны ипотекийн зээлээр санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллана. / ногоон зээлд хаируулан иргэн төр банк хамтарсан гурвалсан гэрээгээр зохицуулах.

*Антун*

3.5.7. Гэр хорооллын дахин төлөвлөлтөөс чөлөөлөгдсөн газар дээр иргэдийн амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх, эрүүл амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор цэцэрлэгт хүрээлэн ГАРДЕН – 2 байгууламжийг байрж байгуулна

3.5.8. Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгохын тулд хогийг худалдан авч дахин боловсруулах чиглэлээр хог боловсруулах, буцаан ашиглах үйлдвэр байгуулж, иргэд хогоо ангилан ялгаж тушаах хувийн хэвшлийг төр дэмжин ажиллах.

3.5.9. Сургуулийн автобус ажиллуулж, хүүхдийн сургуульдаа аюулгүй ирж, буцах нөхцөлийг бүрдүүлнэ

3.5.10. Хотын соёлын өв, дурсгалт барилгуудыг нураахгүйгээр, арчлан хамгаалах, сэргээх завсарлах хэлбэрээр сайжруулан соёлын өвийг хойч үедээ үлдээж ажиллана


## **ДӨРӨВ. АЮУЛГҮЙ АМГАЛАН ГОВЬСҮМБЭР**

### **4.1. БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО**

4.1.1. “Оюутан цэрэг” хөтөлбөрт хамрагдсан оюутнуудыг төрийн албанд ороход нэмэлт оноо өгч ажиллах тал дээр ТАЗ – тэй хамтран ажиллана

#### **төрийн албан хаагчид**

4.1.2. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэх бизнес, төсөл, арга хэмжээний жагсаалтыг шинэчилж, эдийн засгийн тэргүүлэх чиглэл, нийгмийн зорилтот бүлгийг харгалзан үздэг зарчмыг баримтална.



#### **ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ ЭКОСИСТЕМИЙН ТЭНЦВЭРТЭЙ БАЙДАЛ**

4.1.3. Цөлжилттэй тэмцэх шинэ технологи нэвтрүүлж, олон улсын хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.

4.1.4. Ойжуулах, ойг цэвэрлэх, нөхөн сэргээх асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, шинэ технологи нэвтрүүлнэ.

4.1.5. Говь, хээрийн бүсэд газрын доорх усны ордын орчимд үерийн усыг тогтоон барих далан, шингээх худаг, нэвчүүлэх цөөрөм байгуулах замаар усны нөөц баялгийг арвижуулах, нөхөн сэргээх технологи нэвтрүүлнэ

4.1.6. Цөлжилттэй тэмцэх шинэ технологи нэвтрүүлж, олон улсын хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.

### **МАЛЧИН, МАЛ АЖ УХУЙН ТАЛААР**

4.1.7. Хөдөөгийн багуудад 2 цэгт үүрэн холбооны найдвартай сүлжээг оруулж, өндөрлөг цэгт камержуулалт суурьлуулж, малын хулгай болон малчидын аюулгүй байдлыг хангахад чиглэнэ.

*АРДЧИЛСАН НАМ*

000000020



## 2024 оны орон нутгийн ээлжит сонгуульд оролцох Шивээговь сумын Ардчилсан намын мөрийн хөтөлбөр

### ӨМНӨТГӨЛ

Монгол Улсын тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт ардчиллаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх чөлөө, хуулийн засаглал, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөөх баруун төвийн намын хувьд

Шивээговь сумын Ардчилсан нам 2024 оны орон нутгийн ээлжит сонгуульд стратегийн 31 заалт, 6 бүлэг бүхий Шивээговь сумын Эрчимт хөгжлийн төлөвлөгөөг танилцуулж байна.

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Ардчилсан нам 2024 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрөө "Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль", "Төсвийн тогтвортой байдлын тухай хууль", "Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай - Эрх зүйн баримт бичиг, Ардчилсан намын үзэл баримтлал, мөрийн хөтөлбөр болон бусад холбогдох хууль, дүрэмд нийцүүлэн боловсруулав.



## АГУУЛГА

- Эрүүл мэнд нийгмийн хамгаалал
- Дэд бүтэц
- Соёл боловсрол
- Иргэдэд таатай амьдрах орчин
- Мал аж ахуй, газар тариалан
- Үйлдвэрлэл, ЖДҮ-н талаар бодлого



000000021

*Amnyan*

## Эрүүл мэнд нийгмийн хамгаалал

- 1.1 Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөл, эх болон нярайн эндэгдлийг бууруулахад анхаарч суманд нарийн мэргэжлийн эмч нарыг тогтвор суурьшилтай ажилахад дэмжлэг үзүүлнэ
- 1.2 Зүүн гэр хорооллын айл өрхийг цэвэр усны худгийн шугамыг шинэчлэн иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй ус түгээдэг болгоно
- 1.3 Орон нутагт ажиллаж буй залуучуудыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.4 Ахмад настанд зориулсан сэргээн засах, эмчилгээ, сувилгааны нэгжийг байгуулах талаар хувийн хэвшилтэй хамтран ажиллана.
- 1.5 Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийг үргэлжилүүлэн хэрэгжүүлнэ.

## Дэд бүтэц

- 2.1 Сумын төвийг босоо тэнхлэгийн автозамтай хатуу хучилттай замаар холбох ажлыг дуусгах, сумын төв дотроо 3.5 км автозам барих
  - 2.2 Илчлэг Шивээ ОНӨҮГ-ын зуухнаас орон сууцнууд хүртэлх дулаан цэвэр усны шугамыг шинэчлэнэ.
  - 2.3 Иргэд өөрийн өмчилж авсан хашааны газар дээр айл, хөрш, гудамжаараа нэгдэн төлөвлөлт хийж, инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдсон амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ
  - 2.4 Иргэдэд өмчлүүлсэн газарт цахилгааны эх үүсвэрийг бүрэн шийднэ.
- Цахим сум хөтөлбөр хэрэгжүүлж төрийн үйлчилгээг хүнд сурталгүй шуурхай болгоно.

## Соёл. Боловсрол

- 3.1 Дутуу баригдаад байгаа Сургууль, цэцэрлэгийн барилгыг бүрэн ашиглалтанд оруулж материалаг баазыг бэхжүүлнэ.
- 3.2 Хүүхэд харах үйлчилгээг хөгжүүлэх, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 3.3 Соёлын төвийн барилгыг шинээр барьж, холбогдох хэрэгсэл тоног төхөөрөсжөөр хангана.
- 3.4 Малчин өрхийн сургуулийн өмнөх насны хүүхдийг гэр цэцэрлэгт хамруулах сургалтын тогтолцоог бүрдүүлнэ.

000000002

*Амгун*

## Иргэдийн таатай амьдрах орчин

- 4.1 Хойд талын байруудад СӨХ-г байгуулж үйл ажиллагааг нь дэмжин жигдрүүлнэ.
- 4.2 Сумын төвлөрсөн хогийн цэгийг нүүлгэн шилжүүлж шинээр байгуулах
- 4.3 Сумын цэвэрлэх байгууламжыг шинээр байгуулж орчны бохирлыг бууруулна.
- 4.4 Сумын төв гудамжны дагуу тарьсан модны хашааг шинэчилж , 200 мод нэмж тарина.
- 5.5 Эко сум хөтөлбөр хэрэгжүүлж иргэдийн эрүүл амьдрах орчныг сайжруулна.
- 4.6 Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож, буцаан ашиглах хогийг ангилан ялгаж тушаах нэгж байгуулна

## Мал аж ахуй, газар тариалан

- 5.1 Хөдөөгийн малчин өрхийг дэмжин "малжуулах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлнэ.
- 5.2 Чинээлэг малчин хөтөлбөрийг сумандаа хэрэгжүүлнэ.
- 5.3 Хаялга нуурын орчмын газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, Хүлэмжийн АА эрхлэгчдийг нэгдсэн зохион байгуулалтанд оруулж дэмжих
- 5.4 Малчины хоршоо бүлгүүдтэй хамтран ажиллаж бэлчээрийн доройтлыг багасгана.

## Үйлдвэрлэл, ЖДҮ-н талаар бодлого

- 6.1 Шивээ Овоо ХК-тай хамтран ажиллаж Хөдөлмөр хамгаалалын хувцас, хор саармагжуулах бүтээгдэхүүн зэргийг сумын ЖДҮ эрхлэгчээс нийлүүлдэг болгоно
- 6.2 Төрийн албанаас бизнесийн салбарт шилжиж баялаг бүтээх иргэдийнхээ бизнесийн эхлэлтийн хөрөнгө оруулалтыг жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас санхүүжүүлдэг журамд шилжинэ.
- 6.3 Нүүрс химийн үйлдвэр, эрчим хүчний цогцолбор байгуулахад бодлогын дэмжлэг үзүүлнэ.
- 6.4 Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг түшиглэсэн цахилгаан станц барихад бодлогын дэмжлэг үзүүлнэ.
- 6.5 Хууль бус лицензүүдийг цуцлуулж,орон нутгийн өмчит уурхайг байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ

000000003



## МОНГОЛ УЛСЫН ОРОН НУТГИЙН ИТХ-Н 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЯНТАЛ СУМЫН АРДЧИЛСАН НАМААС ДЭВШҮҮЛЖ БУЙ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

### Өмнөтгөл

Монгол Улсын тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт ардчиллаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх чөлөө, хуулийн засаглал, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөөх баруун төвийн намын хувьд

Ардчилсан нам 2024 оны орон нутгийн ээлжит сонгуульд стратегийн 31 заалт, 5 бүлэг бүхий Баянтал сумын Эрчимт хөгжлийн төлөвлөгөөг танилцуулж байна.

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Ардчилсан нам 2024 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрөө “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”, “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”, “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай - Эрх зүйн баримт бичиг, Ардчилсан намын үзэл баримтлал, мөрийн хөтөлбөр болон бусад холбогдох хууль, дүрэмд нийцүүлэн боловсруулав.

АГУУЛГА

НЭГ. СЭРСЭН БАЯНТАЛ .....

ХОЁР. ӨМЧТЭЙ БАЯНТАЛЫНХАН .....

ГУРАВ. БҮТЭЭЛЧ СУМ .....

ДӨРӨВ. ТӨРИЙН ДАРАМТГҮЙ СУМ .....

ТАВ. ИРГЭНДЭЭ ЭЭЛТЭЙ СУМ .....



0000000004

*Amnyan*

## НЭГ. СЭРСЭН БАЯНТАЛ

1.1 Цэцэрлэгийн барилга шинээр барих. Улсын төсөвт суулгуулан 2024-2027 оны хооронд ашиглалтанд оруулах.

1.2 Сумын төвийг Лүн, Сансар гэр хороололтой холбосон сайжруулсан шороон зам 2025оны 5 сараас 2026 оны 8 сард ашиглалтанд оруулах.

1.3 Соёлын төвийн барилга 150 суудалтай. Газрын зөвшөөрөл батлагдсан байгаа. Орчин үеийн тоног төхөөрөмж суурилуулах.

1.4 Нар салхины сэргээгдэх эрчим хүчний цогцолбор байгуулахад бодлогын дэмжлэг үзүүлнэ.

1.5 Төмөр замын өртөө зөрлөгүүдийн орчимд Тээвэр ложистикийн цогцолбор байгуулахад бодлогоор дэмжинэ.

1.6 Малчины хоршоо бүлгүүдтэй хамтран ажиллаж бэлчээрийн доройтлыг багасгана.

1.7 СӨХ-г байгуулж үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлнэ.

1.8 Сумын цэвэрлэх байгууламжыг шинээр барих.

1.9 Талын Илч ОНӨҮГ-ын уурын зууханд өргөтгөл хийж орон сууцнуудыг халуун усны шугманд холбох..

### ХОЁР ӨМЧТЭЙ БАЯНТАЛЫНХАН

2.1 Сумын малчин өрхүүд 2024 оны эхэнд болсон зуданд их өртөж малгүй болаон билээ. Иймд малчих хүсэлтэй өрхийг<sup>14445</sup> дэмжин “малжуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх.

2.2 Чинээлэг малчин хөтөлбөрийг засгийн газрын бодлогийн дагуу сумандаа хэрэгжүүлэх.

2.3 Засгийн газрийн Орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд 126 айлын орон сууц ашиглалтанд оруулах. Манай суманд 101, 102, 103, 104 гэсэн өмчлөлийн дугаартай хувьчлагдсан орон сууц байдаг. Үүнийг өмчлөгч нартай хугацаа заан гэрээ хийж ашиглалтанд оруулах.

2.4 Иргэдэд өмчлүүлсэн газарт цахилгааны эх үүсвэрийг бүрэн холбоно. Лүн болон Сансар гэр хороолол тэлж өрөгжиж байгаатай холблгдуулан.

### ГУРАВ. БҮТЭЭЛЧ СУМ

3.1 Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, Хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийг нэгдсэн зохион байгуулалтанд оруулж дэмжих. Манай суманд хүлэмжинд болон талбайд тариалалт эрхэлдэг хүмүүс байдан. Мөн тариалалт эрхлэх сонирхолтой иргэд илбэг байдаг.

3.2 Сумын төвд Ноос угаах үйлдвэр, ган бөмбөлгийн үйлдвэр, төмрийн хүдэр нойтон баяжуулах үйлдвэр. Дизель түлш боловсруулах үйлдвэр эдгээр аж ахуйн нэгжүүдийг ЖДҮ эрхлэгчидтэй холбож, хамтын ажилгааг сайжруулах.

00000000 -

3.3 Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож, дахин ашиглах хогийг ангилан ялгаж тушаах нэгж байгуулна.

3.4 Жижиг үйлдвэрлэлийг технологийн шийдлээр дэмжихэд төрөөс анхаарч, хэрэгжүүлэх механизмыг бий болгоно.

3.5 Орон нутагт ажил эрхэлж буй залуучуудыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.

#### ДӨРӨВ. ТӨРИЙН ДАРАМТГҮЙ СУМ

4.1 Төрийн албанаас бизнесийн салбарт шилжиж баялаг бүтээх иргэдийнхээ бизнесийн эрхлэлтийн хөрөнгө оруулалтыг жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас санхүүжүүлдэг журамд шилжинэ.

4.2 Хууль бус лицензүүдийг цуцлуулж, орон нутгийн иргэдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

4.3 Цахим сум хөтөлбөр хэрэгжүүлж төрийн үйлчилгээг хүнд сурталгүй шуурхай болгоно.

#### ТАВ. ИРГЭНДЭЭ ЭЭЛТЭЙ СУМ

5.1 Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тогтолцоо бий болгож, оношилгоо үйлчилгээний чанар сайжруулж, иргэдэд хүртээмжтэй болгоно.

5.2 Хүүхэд харах үйлчилгээг хөгжүүлэх, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

5.3 Лүн, Сансар гэр хорооллын айл өрхийг цэвэр усны худагтай болгож. Иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй ус түгээдэг болгоно.

5.4 Сумын төвийн авто замын дагуу мод тарих, хашаалах ногоон байгууламжид мод нэмж тарина.

5.5 Цэцэрлэг, сургуулийн нэг ангийн хүүхдийн тоог 30-аас хэтрүүлэхгүй байх стандартыг барина.

5.6 Малчин өрхийн сургуулийн өмнөх насны хүүхдийг гэр цэцэрлэгт хамруулах сургалтын тогтолцоог хэрэгжүүлнэ.

5.7 Ахмад настанд зориулсан сэргээн засах, эмчилгээ, сувилгааны нэгжийг байгуулах талаар хувийн хэвшилтэй хамтран ажиллана.

0000000005

